



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2021.03.30 № 179

танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Д.МӨНХБАТ ТАНАА

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу танай байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитын тайлан, дүгнэлт, менежмент захидлыг албан шаардлагын хамт хүргүүллээ. Шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэбулган сумын төсвийн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/12/СТА-ТТЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Цэцэрлэг хот 2021 он</p> | <p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Д. Уламбаяр Утас: 70333141 UlambayarD@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Байгалмаа Утас: 70332860 BaigalmaaT@audit.gov.mn Аудитор: Х.Алтанчимэг Утас:90060105 Altanchimegkh@audit.gov.mn</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 1.Аудитын гэрчилгээ..... | 6 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан | 6 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | 6 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 8 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..... | 8 |
| 3.Аудитын тайлан | 10 |
| 3.1. Ерөнхий зүйл | 10 |
| 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй | 10 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт | 10 |
| 3.4 Материаллаг байдал | 11 |
| 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт..... | 11 |
| 3.5.1 Мөнгөн хөрөнгө | 11 |
| 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт..... | 11 |
| 3.5.3 Авлага | 11 |
| 3.5.6 Бараа материал | 12 |
| 3.5.7 Үндсэн хөрөнгө..... | 13 |
| 3.5.8 Өр төлбөр | 14 |
| 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо | 15 |
| 3.5.10 Орлогын данс..... | 15 |
| 3.5.11 Зардлын данс..... | 15 |
| 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 15 |
| 3.7 Шилэн дансны мэдээлэл..... | 19 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 20 |
| 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 20 |
| 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал..... | 23 |
| 4. Менежментийн захидал | 23 |
| 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| НДХ | Нийгмийн даатгалын хэлтэс |
| ХАОАТ | Хүн амын орлогын албан татвар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| МӨОНС | Малчин өрхийн орлого нэмэгдүүлэх сан |

1. Аудитын гэрчилгээ

| | |
|---|---|
|  АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: 976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn | <p>「 ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ Д.МӨНХБАТ ТАНАА</p> |
| <p>2021.03.30 № 136</p> <p>танай _____ -ны № _____ -Т</p> | |
| <p>АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ</p> | |
| <p>Зөрчилгүй дүгнэлт</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Эрдэнэбулган сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Эрдэнэбулган сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p> | |
| <p>Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> | |
| <p>Бусад мэдээлэл</p> <p>Сумын засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.</p> <p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p> | |
| <p>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</p> <p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p> | |
| <p>Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага</p> | |

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|---|----------------|-----------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 3,418,035.6 | 3,662,103.6 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 746,145.0 | 632,281.7 |
| 33 | АВЛАГА | 1,197,266.7 | 1,248,475.8 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,395,265.6 | 1,767,346.1 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 79,358.3 | 14,000.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 38,675,614.5 | 47,215,322.0 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 38,675,614.5 | 47,215,322.0 |
| 39200 | Биет хөрөнгө | 37,135,971.2 | 45,663,926.2 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 1,539,643.3 | 1,551,395.8 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 42,093,650.1 | 50,877,425.6 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,022.0 | 9,626.1 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,022.0 | 9,626.1 |
| 41300 | Өглөг | 1,022.0 | 9,626.1 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 42,092,628.1 | 50,867,799.4 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 42,092,628.1 | 50,867,799.4 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 10,725,524.3 | 10,725,524.3 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 23,710,284.0 | 33,152,390.9 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,656,819.8 | 6,989,884.2 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 42,093,650.1 | 50,877,425.6 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------|---------------------------------|----------------|-----------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 19,785,843.6 | 31,162,538.1 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,078,907.1 | 1,193,790.2 |
| 110 | Орлогын албан татвар | 946,294.6 | 1,070,635.1 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 946,294.6 | 1,070,635.1 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 7,110.0 | 7,245.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 125,502.4 | 115,910.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,738,886.7 | 13,268,171.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,738,513.7 | 13,268,171.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 15,968,049.8 | 16,700,576.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 22,113,251.2 | 21,968,396.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 22,113,251.2 | 21,968,396.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 20,208,651.7 | 21,219,777.0 |

| | | | |
|------|--|--------------|--------------|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 9,489,996.2 | 11,632,737.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,187,204.8 | 1,549,401.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,266,516.0 | 2,171,037.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 747,792.7 | 737,903.5 |
| 2105 | Нормативт зардал | 748,013.5 | 478,707.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 146,431.2 | 136,464.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 12,775.1 | 6,452.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 87,973.0 | 193,994.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,521,949.2 | 4,313,077.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,904,599.5 | 748,619.3 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -2,327,407.6 | 9,194,141.8 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 328,933.9 | 418,970.5 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -2,656,341.5 | 8,775,171.4 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------|--|----------------|-----------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 17,668,928.5 | 18,450,866.1 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,078,907.1 | 1,193,790.2 |
| 110 | Орлогын албан татвар | 946,294.6 | 1,070,635.1 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 946,294.6 | 1,070,635.1 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 7,110.0 | 7,245.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 125,502.4 | 115,910.0 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 125,502.4 | 107,928.6 |
| 1181 | Газрын төлбөр | 0.0 | 7,981.5 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 621,971.6 | 585,114.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 621,971.6 | 585,114.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 15,968,049.8 | 16,671,961.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 16,968,485.7 | 18,005,014.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 16,968,485.7 | 18,005,014.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 15,062,132.9 | 17,248,306.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 9,496,820.7 | 11,622,858.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,187,742.0 | 1,543,429.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,307,558.0 | 2,176,946.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 632,632.1 | 603,684.9 |
| 2105 | Нормативт зардал | 778,476.6 | 497,071.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 171,763.4 | 173,572.1 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 12,991.9 | 6,453.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 98,631.5 | 220,743.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 375,516.6 | 403,546.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,906,352.8 | 756,707.2 |

| | | | |
|------|---|------------|------------|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 700,442.8 | 445,852.0 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 442,215.2 | 396,025.2 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 442,215.2 | 396,025.2 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 442,215.2 | 396,025.2 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -442,215.2 | -396,025.2 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -235,500.0 | -163,690.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 235,500.0 | 163,690.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 22,727.7 | -113,863.3 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 723,417.3 | 746,145.0 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 746,145.0 | 632,281.7 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---|--|------------------------|
| 1 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 44,748,969.6 | 44,748,969.6 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 22,626.2 | 22,626.2 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 44,771,595.7 | 44,771,595.7 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -22,626.2 | -22,626.2 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -2,656,341.5 | -2,656,341.5 |
| 10 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 42,092,628.1 | 42,092,628.1 |
| 11 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 42,092,628.1 | 42,092,628.1 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 666,935.6 | 666,935.6 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 42,759,563.7 | 42,759,563.7 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -666,935.6 | -666,935.6 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 8,775,171.4 | 8,775,171.4 |
| 20 | 2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 50,867,799.4 | 50,867,799.4 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|------|--|------------|-------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 18345474.7 | 17555230.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 17733049.3 | 17157983.88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 17389230.4 | 16903732 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 11499820.1 | 11398937.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1556707.7 | 1515514.494 |

| | | | |
|------|--|------------|-------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2322302.2 | 2172962.318 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 578875.8 | 578729.314 |
| 2105 | Нормативт зардал | 663316.4 | 484647.602 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 180634.3 | 180532.22 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9352.1 | 6453.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 203638.1 | 202837.382 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 374583.7 | 363117.362 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 343818.9 | 254251.88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 281818.9 | 192251.88 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 356925.4 | 233556.801 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 255500 | 163690 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 18345474.7 | 17489735.3 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 13706072.6 | 13341319.96 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3539439.1 | 3909811.825 |
| 33 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 7899.2 | 7224.04 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1092063.8 | 231379.477 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 118324.357 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 52828.983 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 11.195 | 11.389 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 0.029 | 0.029 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 0.919 | 0.94 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 9,328.00 | 9,480.00 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 6,695.00 | 6,851.00 |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 2,633.00 | 2,629.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 919.00 | 940.00 |

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ДҮН |
|------|--|-------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 541919.1842 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 541919.1842 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 512043.3072 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 223920.911 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27915.053 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3984.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 30870.45 |
| 2105 | Нормативт зардал | 15151.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35922.912 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 31748.45017 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 142529.331 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 29875.877 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 10777.986 |

| | | |
|------|--|-------------|
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 19097.891 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 538790.4953 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 538790.4953 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | -3128.6889 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3128.6889 |

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Эрдэнэбулган сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Д.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 22-оос 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэв.

Эрдэнэбулган сумын ТЕЗ нь 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрдэнэбулган сумын ЗДТГ нь тайлант жилд иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэх, үйл ажиллагааны удирдлагаар тасралтгүй хангах, нутгийн захиргааны шийдвэр гаргах тогтолцоог дэмжих зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоол
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар тогтоол
- “Автомашини жишиг норм батлах тухай” Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрдэнэбулган сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд 30 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж нэгтгэлийг онлайнаар бэлтгэж байна.

Эрдэнэбулган сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдлийн түвшинг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд шинж чанар ба агуулгын хувьд өөрчлөлт ороогүй тул төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин болох үр дүнгийн тайлангийн нийт зардал **24,276,668.9** мянган төгрөгийн 1 хувь **242,766.6** мянган төгрөгөөр тооцлоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл **746,145.0** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **632,281.7** мянган төгрөг болж, **113,863.3** мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+) Бууралт(-) |
|----------------------------------|------------------|------------------|-------------------------|
| Төрийн сангийн харилцах | 746,145.0 | 632,281.7 | (113,863.3) |
| НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН | 746,145.0 | 632,281.7 | (113,863.3) |
| Үүнээс, байгууллагын төрлөөр: | | | |
| Сум хөгжүүлэх сан | 29,984.4 | 11,528.4 | (18,456.0) |
| Орон нутгийн ерөнхий орлого | 624,692.0 | 579,452.8 | (45,239.2) |
| Орон нутгийн хөгжлийн сан | 88,340.0 | 41,300.6 | (47,039.4) |
| Хот тохижилт үйлчилгээний газар | 3,128.7 | | (3,128.7) |
| НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН | 746,145.1 | 632,281.8 | (113,863.3) |

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 2.1 буюу 11,528.4 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн, 92.0 хувь буюу 579,452.8 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлого, 5.9 буюу 41,300.6 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл тус тус эзлэж байна.

3.5.2 Авлага

Авлагын эхний үлдэгдэл **1,197,266.7** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,248,475.8 мянган төгрөг болж, 51,209.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

| Авлагын ангилал | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+) Бууралт(-) |
|----------------------------|---------------------|---------------------|-------------------------|
| Байгууллагаас авах авлага | 680.60 | 4,177.40 | 3,496.80 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 1,196,586.10 | 1,244,298.40 | 47,712.30 |
| Нийт дүн | 1,197,266.70 | 1,248,475.80 | 51,209.10 |

| Үүнээс: Байгууллагын төрлөөр ангилбал | | | |
|---------------------------------------|---------------------|---------------------|------------------|
| 1-р сургууль | | 27,976.00 | 27,976.00 |
| 3-р сургууль | 185.50 | | -185.50 |
| 9-р цэцэрлэг | 495.10 | | -495.10 |
| МӨОНС | 33,870.80 | 33,870.80 | 0.00 |
| Сум хөгжүүлэх сан | 1,162,715.30 | 1,182,451.60 | 19,736.30 |
| Хот тохижилт үйлчилгээний газар | | 4,177.40 | 4,177.40 |
| Нийт дүн | 1,197,266.70 | 1,248,475.80 | 51,209.10 |

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 2.3 хувь буюу 27,976.0 мянган төгрөгийн авлагыг 1-р сургуулийн, 2.7 хувь буюу 33,870.8 мянган төгрөгийн авлагыг МӨОНС-ийн авлага, 95.0 хувь буюу 1,182,451.6 мянган төгрөгийн авлагыг сум хөгжүүлэх сангийн авлага, 4,177.4 мянган төгрөгийг ХТҮТ-ийн авлага эзлэж байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагын данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Хот тохижилт үйлчилгээний газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагад төлөх 4,177.4 мянган төгрөгийн шатахууны авлага үүсгэсэн байна.
2. МӨОНС болон СХС-ийн авлагыг барагдуулж бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл **1,395,265,5** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **1,710,669.7** мянган төгрөг болж **318,404.1** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|--|---------------------|--------------------|------------------------|
| Тусгай зориулалттай материал | 160,627.00 | 218,919.50 | 58,292.50 |
| Эм боох материал | 5,891.90 | 24,328.40 | 18,436.50 |
| Бичиг хэргийн материал | 11,115.20 | 15,380.50 | 4,265.30 |
| Аж ахуйн материал | 1,075,106.60 | 1,299,358.10 | 224,251.50 |
| Сэлбэг хэрэгсэл | 2,381.20 | 5,603.20 | 3,222.00 |
| Түлш шатах тослох материал | 4,892.00 | 9,823.10 | 4,931.10 |
| Барилгын засварын материал | 77,605.50 | 93,391.10 | 15,785.60 |
| Хүнсний материал | 21,161.50 | 2,483.60 | -18,677.90 |
| Бусад хангамжийн материал | 20,794.60 | 26,627.10 | 5,832.50 |
| Мал амьтад | 15,690.00 | 17,755.00 | 2,065.00 |
| Дүн | 1,395,265.50 | 1,767,346.1 | 372,080.5 |
| Үүнээс байгууллагын төрлөөр: | | | |
| Тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллага | 1,356,324.70 | 1,671,616.90 | 315,292.20 |
| ЗДТГ | 22,597.70 | 27,338.80 | 4,741.10 |
| ХТҮГазар | 16,343.10 | 11,714.00 | (4,629.10) |
| Дүн | 1,395,265.50 | 1,767,346.1 | 372,080.5 |

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын ихэнх хувь буюу 1,671,616.9 мянган төгрөгийн бараа материалыг тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллага эзлэж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,361,704.4 мянган төгрөгийн, хандив тусламжаар 197,940.0 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 151,506.6 мянган төгрөгийн материал орлогод авсан бөгөөд 1,195,498.8 мянган төгрөгийн материалыг зарцуулж, 2,496.1 мянган төгрөгийн материалыг данс хооронд шилжүүлж, малын нас дэвшил болон акталж устгасан зэрэг бусад байдлаар 141,111.8 мянган төгрөгийн материалыг данснаас хасч нийт 1,339,106.4 мянган төгрөгийн материал зарцуулагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой дараах зөрчил илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

1. Ар манал өрхийн эрүүл мэндийн төв- 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 4017,6 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 1434,6 мянган төгрөгөөр нийт 5452,2 мянган төгрөгөөр,
2. Ар мөнхжин эрүүл мэндийн төв- 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, бараа материал 6817,6 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 1803,9 мянган төгрөгөөр нийт 8621,5 мянган төгрөгөөр
3. Ар мөнгөн чагнуур- 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 4017,6 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 3792,9 мянган төгрөгөөр нийт 7810,5 мянган төгрөгөөр
4. 2-р сургууль-Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй орлогын дүн бараа материал, үндсэн хөрөнгийн хандивын дүнгээс 9,730.0 мянган төгрөгийн алдааг залруулсан
5. 1-р сургууль-Үнэ төлбөргүй авсан бараа материалын болон үндсэн хөрөнгийг 20,522.2 мянган төгрөгөөр үр дүнгийн тайланд нэмж тусгуулах залруулга-

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл **38,675,614.2 мянган төгрөг**, эцсийн үлдэгдэл 47,208.861.4 төгрөг болж 8,533,246.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-------------------------------------|----------------------|----------------------|---------------------------|
| Биет хөрөнгө | 37,135,971.20 | 45,663,926.20 | 8,527,955.00 |
| Биет бус хөрөнгө | 1,539,643.30 | 1,551,395.80 | 11,752.40 |
| Дүн | 38,675,614.50 | 47,215,322.00 | 8,539,807.50 |
| Үүнээс, байгууллагын төрлөөр | | | |
| ТЗШБ | 18,241,219.80 | 28,790,005.50 | 10,548,785.70 |
| ЗДТГ | 845,187.60 | 864,199.20 | 19,011.60 |
| ИТХ | 20,209.10 | 17,815.00 | -2,394.10 |
| ХТҮГ | 19,568,998.00 | 17,543,302.30 | -2,025,695.70 |
| Дүн | 38,675,614.50 | 47,215,322.00 | 8,539,807.50 |

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 61 хувь буюу 28,790,005.5 мянган төгрөгийн хөрөнгийг тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллага, 2 хувь буюу 864,199.2 мянган төгрөгийн хөрөнгийг ЗДТГ, 37.0 хувь буюу 17,543,302.3 мянган төгрөгийг хөрөнгийг ХТҮГ эзэмшиж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 162,468.4 мянган төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 2,997.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 11,177,882.3 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс авсан 1,344,564.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол балансаас баланст шилжүүлсэн 48,987.5 мянган төгрөг, акталсан 6,415,215.4 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ХТҮГ-Үндсэн хөрөнгийг дэлгэрэнгүй бүртгэлийг хянаж үзэхэд элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 172,420.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.
- 1-р сургууль-Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээр 37,028.3 мянган төгрөгийг элэгдлийн зардлыг дутуу тайлагнасныг орлого үр дүнгийн тайланд нэмж залруулга хийлгэсэн
- 2-р сургууль-Элэгдлээ бүрэн нөхсөн-373ш хөрөнгө байгааг өмч хамгаалал байнгын зөвлөлөөр хэлэлцүүлээгүй
- Хоршоололын сургууль-Элэгдлээ бүрэн нөхсөн 38 ш хөрөнгө байгааг өмч хамгаалал байнгын зөвлөлөөр хэлэлцүүлээгүй
- Ирээдүй цэцэрлэг сургууль- Элэгдлээ бүрэн нөхсөн 878 ш хөрөнгө байгааг өмч хамгаалал байнгын зөвлөлөөр хэлэлцүүлээгүй
- 5-р сургууль-Элэгдлээ бүрэн нөхсөн 185 ш хөрөнгө байгааг өмч хамгаалал байнгын зөвлөлөөр хэлэлцүүлээгүй
- . Хоршоололын цэцэрлэг- Элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 28 нэр төрлийн нийт 7,836.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.
- Эрүүл мэндийн төв- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад үндсэн хөрөнгийн шинж чанаргүй элэгдлээ бүрэн нөхсөн нийт 39816.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.
- 6-р цэцэрлэг-Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй, элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн нийт 13,121.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Дээрх зөрчлүүдэд төсвийн шууд захирагчийн аудитаар хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж ажиллах менежмент захидлаар зөвлөмж хүргүүлээ.

3.5.8 Өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл **1,022.0 мянган төгрөг**, эцсийн үлдэгдэл 9,626.1 төгрөг болж 8,604.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - |
|-------------------------------------|----------------|-----------------|------------------|
| Байгууллагад төлөх өглөг | 1,022.0 | 9,626.1 | -8,604.1 |
| <i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i> | | | |
| ЗДГ | 0 | 9,626.1 | -9,626.1 |
| 6-р цэцэрлэг | 1,022.0 | 0 | 1,022.0 |
| ДҮН | 1,022.0 | 9,626.1 | -8604.1 |

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант жилд Эрдэнэбулган сумын ЗДТГ нь НДШ-ийн 9,626.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь төрийн сангийн гүйлгээний программ гацсантай холбоотой байна. ТШЗ-ийн аудитаар тус өр төлбөрийг барагдуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг хүргүүлэн ажилласан байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл **42,092,628.1** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **50,861,302.5** мянган төгрөг болж, **8,768,674.5** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Цэвэр хөрөнгө өмчийн дансны үлдэгдэл /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+, бууралт /-/ |
|----------------------------------|----------------|-----------------|----------------------|
| Засгийн газрын оруулсан капитал | 10,725,524.30 | 10,725,524.30 | 0.00 |
| Хуримтлагдсан үр дүн | 23,710,283.90 | 33,145,894.00 | 9,435,610.10 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,656,819.80 | 6,989,884.20 | -666,935.60 |
| Дүн | 42,092,628.00 | 50,861,302.50 | 8,768,674.50 |

Эх сурвалж: Эрдэнэбулган сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн өмнөх оноос 9,435,610.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь дараах дансдуудын өөрчлөлтүүдтэй холбоотой байна. Үүнд:

- Тайлант үеийн үр дүн 8,768,674.5 мянган төгрөгөөр,
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой -666,935.6 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

3.5.10 Орлогын данс

Эрдэнэбулган сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 31,162,538.1 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 11,376,694.5 мянган төгрөгөөр өссөн байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

1. Татварын орлого 1,193,790.2 мянган төгрөг,
2. Татварын бус орлого 13,268,171.9 мянган төгрөг байна.
3. Тусламж санхүүжилтийн орлого 16,842,872.6 мянган төгрөг байна. Үүнээс: Улсын төсвөөс 13,625,946.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 567,405.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 2,642,296.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 7,224.0 мянган төгрөг

3.5.11 Зардлын данс

Эрдэнэбулган сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 21,968,396.2 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 418,970.5 мянган төгрөг нийт 22,387,366.4 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн өмнөх оноос 8,775,171.4 мянган болж өссөн нь үнэ төлбөргүй хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалсан байна. Тайлант жилд 1,869,821.2 мянган төгрөгийн санхүүжилт хоорондын тооцоог устгах бичилтээр хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. ИТХ- бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас аймгийн Цагдаагийн газарт

- авто машин худалдан авахад 30,000.0 мянган төгрөгийг сумын ИТХ-ын төсвөөс зориулалт бусаар зарцуулсан
2. ИТХ-ном хэвлэлийн зардлаас 15,000.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлэх зардлаас 10,430.0 мянган төгрөгийг нийт 25,430.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансруу оруулж зарцуулсан
 3. 12-р цэцэрлэг- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг ирцийн дэвтэр, нярвын тайлантай тулган шалгахад нийт 19,008.6 төгрөгийн хүнсний материал зарцуулж, 899.7 мянган төгрөгийг зорилтод бүлгийн хүүхдүүдэд өгч 1524.8 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг нөөцөлж үлдээсэн
 4. Эрүүл мэндийн төв -Цалингийн давтан тооцооллоор 4 сарын хоолны хөнгөлөлт 264.0 мянган төгрөгийг илүү олгосон.
 5. Ар манал ЭМТ-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалтыг зөрчин Санхүүгийн байдлын болон үр дүнгийн тайланд 126675,5 мянган төгрөгийн цалин, НДШ-ийг аккруэл суурийн дагуу өглөг болон зарлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.
 6. Ар мөнхжин ЭМТ-Санхүүгийн байдлын болон үр дүнгийн тайланд 142,187,4 мянган төгрөгийн цалин, НДШ-ийг аккруэл суурийн дагуу өглөг болон зарлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй
 7. Ар мөнхжин ЭМТ-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчин тээвэр шатахууныг анхан шатны баримтаас нормоор хөөн шалгахад 681,5 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан.
 8. Ар мөнгөн чагнуур ЭМТ- Санхүүгийн байдлын болон үр дүнгийн тайланд 157230,5 мянган төгрөгийн цалин, НДШ-ийг аккруэл суурийн дагуу өглөг болон зарлагаар хүлээн зөвшөөрч бүртгэхгүй байна.
 9. Ар мөнгөн чагнуур ЭМТ-Төсвийн тухай хуулийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалтуудыг зөрчиж, Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаалын 1-р хавсргалтад заасан төсөвт зохицуулалт хийхгүйгээр 438.0 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.
 10. 1-р сургууль-Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн
 11. 1-р сургууль-Цалингаас түүвэрлэн шалгахад 12 сарын цалинд илүү цаг гэж олгосон /Ковидаар ажилласан багш нарт постонд гарсан ажиллагсдад өгсөн/
 12. 2-р сургууль-Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн
 13. 3-р сургууль-Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн
 14. 5-р сургууль-Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн
 15. 3-р цэцэрлэг- Цалинг түүвэрлэн шалгахад зарим ажилчдын ХХОАТ-ын тооцож суутгаагүй, зарим саруудад илүү, дутуу тооцож, албан хаагчдын гарт олгох цалинг 429.8 мянган төгрөгөөр илүү олгосон
 16. Мөн ХТҮГ, ЗДТГ, ИТХ, 6-р цэцэрлэг, Хоршоололын цэцэрлэг, Ар Манал ЭМТ, Энхжин ЭМТ, Мөнгөнчагнуур ЭМТ зэрэг байгууллагуудад тайлант жилд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төсвийн шууд захирагчдын дээрх зөрчилд холбогдох шийдвэрүүдийг хүргүүлсэн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

✓ **Орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Орон нутгийн төсвийн орлогыг 1,107,729.0 мянган төгрөгөөр анх төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг 4,440.0 мянган төгрөгөөр бууруулан 1,103,289.0 мянган төгрөгөөр анх баталсан байна.

Баталсан орлогоос үйл ажиллагааны орлогыг 950.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 4,340.0 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны хураамжийг 1,050.0 мянган төгрөгөөр бууруулсан нь жил бүр орлого тасарч байгаатай холбоотой байна.

Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөвт зохицуулалт хийх тухай тухай 05-р тогтоолд сумын төсвийн орлогоор 11 нэр төрлийн 1,287,079.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,549,131.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 20.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Сумын орон нутгийн төсвийн орлого

/мянган төгрөг/

| № | Орлогын нэр төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|----|--|--------------|--------------|-------------|---------|
| | НИЙТ ОРЛОГО | 1,287,079.00 | 1,549,131.70 | 262,052.70 | 1.20 |
| | ТАТВАРЫН ОРЛОГО | 963,009.00 | 1,193,790.10 | 230,781.10 | 1.24 |
| | Орлогын албан татвар | 847,534.00 | 1,070,635.10 | 223,101.10 | 1.26 |
| | Хүн амын орлогын албан татвар | 847,534.00 | 1,070,635.10 | 223,101.10 | 1.26 |
| 1 | Үйл ажиллагааны орлого | 47,380.00 | 74,436.60 | 27,056.60 | 1.57 |
| 2 | Шууд бус орлого | 51,790.00 | 170,551.00 | 118,761.00 | 3.29 |
| 3 | Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүүнээс/ | 690,964.00 | 701,896.00 | 10,932.00 | 1.02 |
| 4 | Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого | 57,400.00 | 123,751.50 | 66,351.50 | 2.16 |
| 5 | Бууны албан татвар | 6,305.00 | 7,245.00 | 940.00 | 1.15 |
| 6 | Улсын тэмдэгтийн хураамж | 27,660.00 | 17,623.80 | (10,036.20) | 0.64 |
| 7 | Газрын төлбөр | - | 7,981.50 | 7,981.50 | #DIV/0! |
| 8 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны | 2,510.00 | 2,970.60 | 460.60 | 1.18 |
| 9 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 79,000.00 | 87,334.10 | 8,334.10 | 1.11 |
| | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 324,070.00 | 355,341.60 | 31,271.60 | 1.10 |
| 10 | Хүү торгуулийн орлого | 304,070.00 | 352,357.70 | 48,287.70 | 1.16 |
| 11 | Нэр заагдаагүй бусад орлого | 20,000.00 | 2,983.90 | (17,016.10) | 0.15 |

Тайлант жилд 9 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 10,036.2 мянган төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 17,016.1 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 заалтыг үндэслэн сургууль хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглоно гэж заасны дагуу тамхины зөвшөөрөл хүссэн дэлгүүрийн худалдаа эрхлэгч нарт зөвшөөрөл олгогдоогүй, иргэд газрын гэрчилгээгээ шинээр солиулах иргэний үнэмлэхний сунгалт, худалдах худалдан авалт багассан, нэр заагдаагүй бусад орлогын дансанд төвлөрдөг байсан газрын төлбөрийн орлогыг шинэ дансанд төвлөрүүлдэг болсон зэрэгтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2020 оны төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 19,610,911.5 мянган төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор 18,619,459.1 мянган төгрөг болж 1,488,393.0 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Хүснэгт 8. Сумын төсвийн төлөвлөлт

/мянган төгрөг/

| № | Байгууллага, орлогын нэр төрөл | Анх баталсан дүн | Тодотгон баталсан дүн | Зөрүү |
|---|--|---------------------|-----------------------|----------------------|
| 1 | Сумын төсвийн татварын орлого | 1,113,289.0 | 1,297,079.0 | 193,790.0 |
| 1.1 | Татварын орлого | 893,219.0 | 963,009.0 | 69,790.0 |
| 1.2 | Сумын төсвийн татварын бус орлого | 210,070.0 | 324,070.0 | 114,000.0 |
| 2 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 10,000.0 | 10,000.0 | - |
| 3 Санхүүжих зарлагын эх үүсвэр | | | | |
| 3.1 | ОНХС-ийн орлогын шилжүүлэг | 129,814.8 | 126,517.4 | (3,297.4) |
| 3.2 | СӨБ-ийн үйлчилгээ | 6,279,013.6 | 5,536,840.3 | (742,173.3) |
| 3.3 | ЕБС-ийн үйлчилгээ | 11,044,359.1 | 10,389,498.2 | (654,860.9) |
| 3.4 | Соёлын үйлчилгээ | | | - |
| 3.5 | ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ | 258,354.4 | 257,460.4 | (894.0) |
| 3.6 | 2019 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн | 403,000.0 | 623,085.8 | 220,085.8 |
| 3.7 | 2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн | 52,580.6 | 58,478.0 | 5,897.4 |
| | Нийт дүн | 19,610,911.5 | 18,619,459.1 | (1,488,393.0) |
| 4. Төсөв захирагчийн зарцуулах дүн | | | | |
| 4.1 | Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 247,376.3 | 253,376.3 | 6,000.0 |
| 4.2 | Засаг даргын тамгын газар | 1,268,912.7 | 1,169,847.7 | (99,065.0) |
| 4.3 | Орон нутгийн нөөц хөрөнгө | | | - |
| 4.4 | Орон нутгийн хөгжлийн сан | 182,395.4 | 184,995.4 | 2,600.0 |
| 4.5 | Сум хөгжүүлэх сан | 260,000.0 | 260,000.0 | - |
| 4.6 | Сургуулийн өмнөх боловсрол | 6,279,013.6 | 5,536,840.6 | (742,173.0) |
| 4.7 | Ерөнхий боловсролын сургууль | 11,114,859.1 | 10,459,998.1 | (654,861.0) |
| 4.9 | Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ | 258,354.4 | 257,460.4 | (894.0) |
| 4.10 | Аймагт төвлөрүүлэх орлого | | 496,940.60 | |
| | Нийт дүн | 19,610,911.5 | 18,619,459.1 | (1,488,393.0) |

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн үйл ажиллагааны орлогыг 41,560.0 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 440.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан бол шууд бус, хөрөнгийн хөрөнгө борлуулсны болон хүү торгуулийн зэрэг 4 нэр төрлийн орлогыг 225,790.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Харин төсвөөс авах санхүүжилтийн эх үүсвэрийг 1,175,242.4 мянган төгрөгөөр бууруулж 16,991,880.1 мянган төгрөгөөр баталсан нь Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын /сургууль, цэцэрлэг/ үйл ажиллагаа түр хаасантай холбоотой, мөн томилолтын, зочид төлөөлөгч хүлээн авах, урсгал засварын, хөрөнгийн зэрэг зардлууд зарцуулагдахааргүй болсонтой холбоотой байна.

✓ **Орон нутгийн төсвийн зардлын талаар:**

Эрдэнэбулган сум нийт зардлын төлөвлөгөөг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 08 тоот тогтоолоор 19,610,911.5 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн

05 тоот тогтоолоор төсвийн зохицуулалт хийж ТЗШ-ийн байгууллагаас 1,397,928.0 мянган төгрөгийг, ЗДТГ-аас 99,065.0 мянган төгрөгийн хасах тодотгол хийсэн бол ОНХС-г 2,600.0 мянган төгрөгөөр, ИТХ-г 6,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэх тодотгол хийж **18,619,459.1** мянган төгрөгөөр баталсан байна.

Гэтэл төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 18,345,474.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь 12-р сард ТЗШ-ийн байгууллагуудын төсвөөс сангийн яам төсөвт зохицуулалт хийн буцаан татсантай холбоотой байна.

Нийт зардлын 13,706,072.6 мянган төгрөг буюу 74.8 хувийг тусгай зориулалтын шилжүүлэгээс 3,539,439.1 мянган төгрөг буюу 19.3 хувийг орон нутгийн төсвөөс, 1,092,063.8 мянган төгрөг буюу 5.9 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 17,555,230.7 мянган төгрөг буюу 95.7 хувьтай байгаа нь урсгал зардлаас 575,065.4 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 123,368.6 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангаас 91,810.0 мянган төгрөг хэмнэгдэж зарцуулаагүйтэй холбоотой байна.

✓ **Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн талаар:**

1. ОНХС-аар 2020 онд 4 төсөл арга хэмжээнд нийт 184,995.4 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 173,556.8 мянган төгрөг зарцуулагдсан байна. Үүнээс барилга байгууламжид 50,000.0 мянган төгрөг, их засварт 20,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмжид 103,556.8 мянган төгрөг тус тус зарцуулж 41,300.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг нийцлийн аудитаар үзэж байна.
2. Сум хөгжүүлэх санд нийт 265 хүнтэй холбоотой 1,182,451.6 мянган төгрөгийн зээлийн авлагатайгаас хэвийн зээл 39 хүнтэй холбоотой 168,690.0 мянган төгрөг, хугацаа хэртэрсэн зээл 125 хүнтэй холбоотой 393,655.5 мянган төгрөг, чанаргүй зээл 96 хүнтэй холбоотой 620,106.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант жилд 143,953.7 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт төвлөрч, 2,910.3 мянган төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлж ажилласан боловч үндсэн үйл ажиллагааны орлогоос зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг зөв тооцон бүртгэж ажиллаагүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсөв захирагчаас 507,370.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 31,419.7 мянган төгрөг нийт 538,790.5 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр ирсэн санхүүжилтээс бараа үйлчилгээний зардалд 512,043.3 мянган төгрөгийг, урсгал шилжүүлэгт 28,875.8 мянган төгрөгийг тус тус зарцуулж 3,128.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 52 мэдээллээс 51 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. *Хоршоолол цэцэрлэг- Шилэн дансны мэдээллийг 2020 оны 3-р улирлын байдлаар СХДД-аас ирүүлсэн мэдээлэлд үндсэнлэн шалгахад 111 мэдээлэл байршуулахаас 72 мэдээллийг байршуулсан байна. Үүнээс 21 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Мөн төсөв хөрөнгөтэй холбоотой 5,856.5 мянган төгрөгийн 5 тушаалыг цахим системд байршуулаагүй байна*
2. *6-р цэцэрлэг- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг тулган шалгахад тайлант хугацаанд оруулбал зохих 111 мэдээллээс 33 мэдээллийг хугацаа хоцроосон.*
3. *3-р цэцэрлэг- Шилэн дансны цахим хуудаст 106 мэдээллийг байршуулсан, үүнээс 72 мэдээллийг хугацаанд нь 34 мэдээллийг хугацаа хоцроосон*
4. *Ирээдүй сургууль- Шилэн дансны хуулийн дагуу 150 мэдээлэл оруулахаас 15 мэдээлэл хугацаа хоцроосон*
5. *Ирээдүй цэцэрлэг- Шилэн дансны хуулийн дагуу 126 мэдээлэл оруулахаас 34 мэдээлэл хугацаа хоцроосон*
6. *Хоршоолол сургууль- Шилэн дансны хуулийн дагуу 93 мэдээлэл оруулахаас 43 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна.*

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар 147,876.8 мянган төгрөгийг аудитын явцад залруулж, 954,612.1 мянган төгрөгийн зөрчилд аудитын шийдвэр хүргүүлсэн байна.

Хүснэгт №9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | /мянган төгрөг/ Хэрэгжилтийн хувь |
|------------------------|---------------------|------------------|----------|------------------|--------------|-----|--------------------------------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | | | | | | | |
| Албан шаардлага | 2 | 118,743.8 | 2 | 118,743.8 | | | 100 |
| Зөвлөмж | 1 | 835,868.3 | | | | | 50 |
| Нийт | 3 | 954,612.1 | 2 | 118,743.8 | | | |

1. СХС-ийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч хугацаа хэтэрсэн чанаргүй зээлдэгч нарт авах арга хэмжээ авч ажиллаж байгаа гэсэн албан бичгээр зөвлөмжийн хариуг ирүүлсэн боловч энэ жил хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос 177,893.3 мянган төгрөгөөр өсч 1,013,761.6 мянган төгрөг болсон үзүүлэлттэй байгаа тул биелэлтийг 50 хувьтай байна гэж үзэн тайлант оны аудитаар ахин зөвлөмж хүрүүлэх шаардлагатай гэж үзсэн.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Эрдэнэбулган сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 27 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 29 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Эрдэнэбулган сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №10.Аудитын дүнгийн талаар:

| № | Байгууллагын төрөл | Хамрагдсан | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | |
|------------|---------------------------|------------|---------------------------|--------------------|----------------|--------------------------------|-----------|----------------|
| | | Хамрагдсан | Гүйцэтгэсэн | | | Бүгд | Үүнээс | |
| | | | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Итгэл үзүүлсэн | | Зөрчилгүй | Хязгаарлалттай |
| 1 | Төсөвт байгууллага | 28 | 13 | 11 | 4 | 13 | 12 | 1 |
| 2 | Орон нутгийн хөгжлийн сан | 1 | | 1 | | | | |
| 3 | Сум хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | |
| ДҮН | | 30 | 13 | 13 | 4 | 13 | 12 | 1 |

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 29 төсөвт байгууллагыг аудитад хамруулж 12 байгууллагад дүгнэлт гаргаж, 13 байгууллагыг түүвэрт хамруулж, 4 байгууллагад итгэл үзүүлсэн байна. Үүнээс 11 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт хүргүүлж, Эрдэнэбулган сумын ИТХ-д “Хязгаарлалттай” санал дүгнэлт хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 904,882.7 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч 89,165.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 762,618.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 51,209.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,888.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт №11. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

| Аудитын нэр | Залруулсан алдаа | | Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | |
|----------------------|------------------|-----------|-------------------------------------|-----------|---|---------|-----------------------|----------|---------------|-----------|
| | | | | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ХТҮГ | | | 4 | 176,598.2 | | | 1 | 4,177.4 | 3 | 172,420.8 |
| ЗДТГ | | | 3 | 9,626.1 | | | 1 | 9,626.1 | 2 | |
| ИТХ | | | 4 | 55,430.0 | | | 1 | 30,000.0 | 3 | 25,430.0 |
| ЭМТ | | | 2 | 40,080.7 | 1 | 264.0 | | - | 1 | 39,816.7 |
| Ар манал ЭМТ | 1 | 5,452.20 | 3 | 126,775.5 | 1 | 100.0 | | | 2 | 126,675.5 |
| Ар мөнхжин ЭМТ | 1 | 8,621.50 | 3 | 142,868.9 | | - | 1 | 681.5 | 2 | 142,187.4 |
| Ар мөнгөнчагнуур ЭМТ | 1 | 7,810.50 | 3 | 157,668.5 | | | 1 | 438.0 | 2 | 157,230.5 |
| Хоршоолол цэцэрлэг | | | 3 | 13,692.8 | | | 1 | 5,856.5 | 2 | 7,836.3 |
| 6-р цэцэрлэг | | | 3 | 13,121.9 | | | 1 | - | 2 | 13,121.9 |
| 3-р цэцэрлэг | | | 1 | 429.8 | | | 1 | 429.8 | - | |
| 12-р цэцэрлэг | - | - | 1 | 1,524.8 | 1 | 1,524.8 | | | | |
| 1-р сургууль | 2 | 57,550.50 | 4 | 30,750.6 | | | | | 4 | 30,750.6 |
| 2-р сургууль | 1 | 9,730.00 | 2 | 17,668.0 | | | - | | 2 | 17,668.0 |

| | | | | | | | | | | |
|--------------------|----------|-----------------|-----------|------------------|----------|----------------|-----------|-----------------|-----------|------------------|
| 3-р сургууль | | | 2 | 8,946.9 | | | | | 2 | 8,946.9 |
| Хоршоолол сургууль | | | 3 | 1,118.3 | | | 1 | | 2 | 1,118.3 |
| Ирээдүй цэцэрлэг | | | 2 | - | | | 1 | | 1 | |
| Ирээдүй сургууль | | | 2 | - | | | 1 | | 1 | |
| 5-р сургууль | | | 3 | 19,415.9 | | | | | 3 | 19,415.9 |
| НИЙТ ДҮН | 6 | 89,165.7 | 48 | 815,716.9 | 3 | 1,888.8 | 11 | 51,209.3 | 34 | 762,618.8 |

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

Эрдэнэбулган сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1,081,934.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 7,339.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 33,780.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,040,813.9 мянган төгрөгийн зөрчилд менежмент захидлаар зөвлөмж хүргүүлээ.

Хүснэгт №12 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| № | Байгууллагын нэр | Залруулсан алдаа | | Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | |
|-----------------|-------------------|------------------|----------------|-------------------------------------|--------------------|---|-----------------|---------------|--------------------|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сум хөгжүүлэх сан | | | 1 | 1,013,761.6 | | | 1 | 1,013,761.6 |
| 2 | Нэгдсэн тайлан | 1 | 7,339.3 | 2 | 60,833.1 | 1 | 33,780.8 | 1 | 27,052.3 |
| НИЙТ ДҮН | | 1 | 7,339.3 | 3 | 1,074,594.7 | 1 | 33,780.8 | 2 | 1,040,813.9 |

1. Эрдэнэбулган сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн дансанд 7,339.3 мянган төгрөгийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал тайлагнасныг жинхэнэ зардалд тусгуулж аудитын явцад залруулга хийлгэлээ.
2. Сум хөгжүүлэх санд нийт 260 хүнтэй холбоотой 1,182,451.6 мянган төгрөгийн зээлийн авлагатайгаас хэвийн зээл 39 хүнтэй холбоотой 168,690.0 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 125 хүнтэй холбоотой 393,655.5 мянган төгрөг, чанаргүй зээл 96 хүнтэй холбоотой 620,106.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант жилд 143,953.7 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт төвлөрч, 2,910.3 мянган төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлж ажилласан боловч үндсэн үйл ажиллагааны орлогоос зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг зөв тооцон бүртгэж ажиллаагүй байгаа ч хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлдэгч нарыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллаж байгаа зэрэг арга хэмжээ авч байгаа тул зөвлөмж хүргүүлэхээр боллоо.
3. Тайлант жилд 9 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 10,036.2 мянган төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 17,016.1 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь ковид-19 цар тахлаас шалтгаалж байгаа тул орлогыг жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэхээр боллоо.
4. Эрдэнэбулган сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд Малчин өрхийн орлого нэмэгдүүлэх сангийн 33,780.8 мянган төгрөгийн авлага байгаагаас тайланд онд огт барагдаагүй байгаа тул тус авлагыг барагдуулахад холбогдох арга хэмжээ авч, сум хөгжүүлэх сангийн авлагын дансанд бүртгэх албан шаардлагыг хүргүүлэхээр боллоо.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитад төсөв батлах тухай тогтоолыг үнэн зөв хийсэн эсэхийг нягтлах

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.1 ОРЛОГЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.1.1 **Илрүүлэлт:** Тайлант жилд 9 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 10,036.2 мянган төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 17,016.1 мянган төгрөгөөр тус тус тасарсан тул орлогыг жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэхээр боллоо.

1.1.2 **Эрсдэл:** Орон нутгийн орлого дутуу төвлөрөх

1.1.3 **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэн төсөвт төвлөрөх орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, орлогыг жигд ханган биелүүлж ажиллах.

1.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

1.2 Авлагын данстай холбоотой асуудал:

1.2.1 **Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх санд нийт 260 хүнтэй холбоотой 1,182,451.6 мянган төгрөгийн зээлийн авлагтайгаас хэвийн зээл 39 хүнтэй холбоотой 168,690.0 мянган төгрөг, хугацаа хэртэрсэн зээл 125 хүнтэй холбоотой 393,655.5 мянган төгрөг, чанаргүй зээл 96 хүнтэй холбоотой 620,106.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант жилд 143,953.7 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт төвлөрч, 2,910.3 мянган төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлж ажилласан боловч үндсэн үйл ажиллагааны орлогоос зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг зөв тооцон бүртгэж ажиллаагүй байна.

1.2.2 **Эрсдэл:** Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

1.2.3 **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах

1.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

АУДИТЫН ТАЙЛАН

Бэлтгэсэн: Аудитор *X. Алтанчимэг* Х.Алтанчимэг
 Анхан шатанд хянасан: Аудитын менежер *Т. Байгалмаа* Т.Байгалмаа
 Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор *Д. Уламбаяр* Д.Уламбаяр

Хавсралт

1 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | |
|---|--|--|
| Огноо: 2021.03.25 | Аудитын нэр: Эрдэнэбулган сумын төсвийн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: АРА-2021/18/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: Эрдэнэбулган сумын ТЕЗ | мянган төгрөгөөр | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|-------------|---------------------------------------|---|------------------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | Эрдэнэбулган сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн дансанд 7,339.3 мянган төгрөгийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал тайлагнасныг жинхэнэ зардалд тусгуулж аудитын явцад залруулга хийлгэлээ. | 7339.3 | Залруулга хийв | Засаг дарга, Санхүү албаны дарга | Д.Мөнхбат, Д.Энхжаргал |
| 2 | Сум хөгжүүлэх санд нийт 260 хүнтэй холбоотой 1,182,451.6 мянган төгрөгийн зээлийн авлагтайгаас хэвийн зээл 39 хүнтэй холбоотой 168,690.0 мянган төгрөг, хугацаа хэртэрсэн зээл 125 хүнтэй холбоотой 393,655.5 мянган төгрөг, чанаргүй зээл 96 хүнтэй холбоотой 620,106.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант жилд 143,953.7 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт төвлөрч, 2,910.3 мянган төгрөгийн хүүгийн орлого бүрдүүлж ажилласан боловч үндсэн үйл ажиллагааны орлогоос зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг зөв тооцон бүртгэж ажиллаагүй байна | 1,013,761.6 | Зөвлөмж хүргүүлэв | Засаг дарга, Санхүү албаны дарга | Д.Мөнхбат, Д.Энхжаргал |

| | | | | | |
|---|--|------------------|----------------------------|----------------------------------|------------------------|
| 3 | Тайлант жилд 9 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 10,036.2 мянган төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 17,016.1 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. | 27,052.3 | Зөвлөмж хүргүүлэв | Засаг дарга, Санхүү албаны дарга | Д.Мөнхбат, Д.Энхжаргал |
| 4 | Эрдэнэбулган сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд Малчин өрхийн орлого нэмэгдүүлэх сангийн 33,780.8 мянган төгрөгийн авлага байгаагаас тайланд онд огт барагдаагүй байгаа тул тус авлагыг барагдуулахад холбогдох арга хэмжээ авч, сум хөгжүүлэх сангийн авлагын дансанд бүртгэ албан шаардлагыг хүргүүлэхээр боллоо | 33,780.8 | Албан шаардлага хүргүүлэв. | Засаг дарга, Санхүү албаны дарга | Д.Мөнхбат, Д.Энхжаргал |
| | ДҮН | 1,081,934 | | | |



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 119/А0370214
АРА-2021/02-СА-ТБ

Цэцэрлэг

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Эрдэнэбулган сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд Малчин өрхийн орлого нэмэгдүүлэх нэртэй санд 7 иргэнтэй холбоотой 5 жилийн насжилттай 33,780.8 мянган төгрөгийн авлагатайгаас тайлант жилд авлага огт барагдаагүй, тус сан нь Төсвийн тухай хуулийн 18-р зүйл, 2019 оны ЗГ-ын тусгай сангийн тухай хууль зэрэгтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын ерөнхий аудиторын 2019 оны а/95 дугаар тушаалаар баталсан төлбөрийн акт, албан шаардлага өгөх журам"-ын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх авлагыг барагдуулахад тодорхой арга хэмжээ авч, сангийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлж, Төсвийн тухай хууль болон, 2019 оны ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг мөрдөж ажиллах

Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дарга Эрдэнэбулган сумын засаг дарга Д.Мөнхбат, санхүү албаны дарга Б.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитын менежер

Аудитор:



Т.Байгалмаа

Х.Алтанчимэг